

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
СЭЛЭНГЭ АЙМАГТ ХАМААРАЛТАЙ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ  
/2009 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2010.03.11

Сүхбаатар

№	Бодлогын зорилт	Хэрэгжилт	Хувь		
			2009	2008-2012	
<p align="center"><b>Нэг. Хүн ам, нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилт:</b></p> <p>Гэр бүлийг дэмжин тэтгэх, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулна.</p>					
<p align="center"><b>1.1 Эрүүл мэндийн бодлого</b></p>					
1	1.1.1	<p>Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын “Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагдсан “Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл аж төрөх ёс” журмыг сурталчлах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн бүх шатны эмнэлгүүд сарын аян зохион байгуулж, “Хөдөлгөөн-эрүүл мэнд”, хөдөлгөөний хомсдлоос үүсэлтэй өвчин эмгэгээс сэргийлэх, хөдөлгөөний ач тусын талаарх сурталчилгааг орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, 54 байгууллагуудын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, 5400 гаруй хүнийг хамрууллаа. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 05 дугаар “Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу “Биеийн тамир, эрүүл мэнд” уриан дор орон даяар явагдсан нийтийн биеийн тамирын уралдааныг аймаг орон нутагтаа зохион байгуулсан амжилтаар Сэлэнгэ аймаг 3-р байрт шалгарч, Монгол Улсын Ерөнхий сайдын батламж, мөнгөн шагналаар шагнагдлаа. 770 гаруй эмч ажиллагсдыг бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулж, эмчлүүлэгчдэд зориулан “Хорт зуршил, түүний хор уршиг”, “Ходоодны архаг үрэвсэл, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Хеликобактерийн тухай”, “Эмийн үйлдэл, нас, хүйс, удамшил, өдрийн хэмнэлээс хамаарах нь”, “Хүн бүр хийж хэвших 10 дасгал” сэдэвт сургалтыг явуулж, давхардсан тоогоор 800 гаруй хэвтэн эмчлүүлэгчид хамрагдсан. Аймгийн хэмжээнд 2009 онд 26 төрлийн сэдвээр давхардсан тоогоор 43560 хүнд эрүүл мэндийн болон эрүүл ахуйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажиллалаа. Тайлант онд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-тай тэмцэх тандалт судалгааны алба, “Итгэл” ТББ-тай хамтран “100 хувь бэлгэвчийн хэрэглээ” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар сумаас үе тэнгийн 25 сургагч багш бэлтгэж, Эх нялхсын эрүүл мэндийн эрдэм шинжилгээний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв,</p>	100	50

			<p>ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албатай хамтран “ХДХВ/ДОХ/БЗДХ-ын лабораторийн оношилгоог сайжруулъя” сургалтанд аймгийн Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгийн 16 лаборант, сум, өрхийн эмнэлгийн эрхлэгч, вакцины сувилагч, нөөц вакцины сувилагч нийт 87 хүнийг Эрүүл мэндийн газраас Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албатай хамтран зохион байгуулсан “Аюулгүй дархлаажуулалтыг бэхжүүлье” сургалтанд хамрууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний үеэр 9 сум, 2 тосгон, 4 албан байгууллагын ажилтнуудад эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, 8628 иргэдэд үзлэг, оношилгоо, шинжилгээгээр үйлчлэхэд 4180 иргэн өвчтэй илэрч үүнээс 315 иргэнийг хяналтанд авч 916 өвчтөнг эмчилгээний төлөвлөгөөнд хамруулсан байна. Тус арга хэмжээний үр дүнд иргэдийн эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх боломжийг бүрдүүлэн иргэдэд эрүүл мэндийн зөв зан үйлийг сурталчлан таниулах ажил үр дүнгээ өгч байна.</p>		
2	1.1.7	Хүн ам, ялангуяа өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг боловсронгуй болгож, хөдөөгийн хүн амд үйлчлэх явуулын эмнэлгийн тогтолцоог бүрдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.	<p>Хүн амд эрүүл мэндээ хамгаалах, өвчлөхөөс сэргийлэх, зөв зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр бүх сумдад сүрьеэ өвчний талаар мэдээллийн самбар байрлуулж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Сэлэнгэ-Теле студитэй хамтран “Эрүүл мэндийн цаг” тусгай дугаарыг сард 2 удаа гаргах арга хэмжээг авч ажиллаж байна. Мандал-Сүхбаатар, Сүхбаатар-Мандал чиглэлээр зохион байгуулсан галт тэрэгний аянд ерөнхий боловсролын сургуулийн 12 сурагчийг оролцуулж зорчигчдод “Сүрьеэ эдгэрдэг өвчин” сэдвээр сурталчилгаа хийлгэх, Сүхбаатар сумын 35 байгууллагын 1108 ажиллагсдад “Бид сүрьеэг зогсоож чадна” сэдвээр ажлын байран дээрх сургалт, үе тэнгийн сургагч 95 хүүхдийг бэлтгэн, давхардсан тоогоор 5000 гаруй хүүхэд багачуудад гараа зөв угааж хэвших, амны хөндийн эрүүл мэнд, архи, тамхины хор уршиг, зөв зохистой хооллолт, хөдөлгөөн эрүүл мэнд, БЗДХ-аас сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалтуудыг хамтран зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж, 19540 гаруй хүүхэд, өсвөр үеийнхийг хамруулсан байна. Томуугийн А хүрээний Н1N1 вирусийн халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 5 захирамж гарган, нийт аж ахуйн нэгж, байгууллагад ариутгал халдваргүйжилт, иргэд болон хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг тандалт хийж, сургалт сурталчилгааны ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, түүнд 55800 хүнийг хамруулан, сургалт сурталчилгаа, эм тариа, амны хаалт, хүчилтөрөгч, ариутгалын бодис, шатахуун, холбоо, тоног төхөөрөмж худалдан авах, хэвлэл мэдээллээр сурталчлах зэрэг арга хэмжээнд аймгийн төсвөөс 25,6 сая төгрөгийг зарцууллаа. Мөн эмийн сангуудыг уртасгасан цагаар</p>	100	50


			ажиллуулах, багш нарыг гудамж талбайд эргүүл хийлгэх, 24 цагийн жижүүрээр ажиллуулах, суралцагчдыг теле хичээлд хамруулах, барааны захын үйл ажиллагааг зогсоох, бар, рестораны ажиллах цагийг хязгаарлах, олон нийтийн арга хэмжээг хориглох зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, цагдаа, цэргийн ангиудад зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтыг зохион байгуулж нийт 1500 гаруй иргэд хамрагдлаа. “Халдварт бус өвчинтэй тэмцэх, сэргийлэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Мэдээлэл, сургалт, сурталчилгааны сангийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн яамнаас халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшинг тогтоох сорилтонд Сүхбаатар сумын 2100 өрхөөс 95 өрхийг сонгон хамрууллаа. 17 сум, 5 тосгонд нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг хийж 28261 иргэд хамрагдаж, алслагдсан орон нутгийн хүн ам, ялангуяа малчид, тариаланчид, захын хорооллын оршин суугчид, эмзэг бүлгийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тухайн амьдарч буй нутаг дэвсгэрт нь хүрч үйлчлэх явуулын амбулаторийн үйлчилгээг Түшиг сумаас эхлүүлж 2264 иргэнд үйлчилснээс өвчтэй 1787 илэрч, 117 хүнийг эмчлэн, 62 хүнийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд авснаар иргэдийн өвчлөлийг эрт илрүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой арга хэмжээ боллоо.		
3	1.1.9	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлж, аймгийн түвшинд өргөжүүлнэ.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Байгалийн голомтод халдварт өвчинтэй тэмцэх үндэсний төвтэй хамтран хачгийн суурин судалгааг Ерөө суманд хийж туршлага судаллаа. Гар, хөл амны өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай сэрэмжлүүлэг, зөвлөмжийн хамт нийт сум, өрхийн эмнэлгүүдэд хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Томуугийн халдварын дэгдэлтийн үед хорт хавдар, сүрьеэ чихрийн шижин, зүрх судасны өвчтэй, даралт ихтэй, уушигны архаг өвчтэй хүмүүсийг хяналтандаа авч, гэрийн эргэлт, үзлэг хийж хяналт тавин ажиллах талаар сум, өрхийн эмч нарт үүрэг өгч ажилласнаар 4500 гаруй хүнийг хяналтанд авч зөвлөгөө өглөө. “Цар тахлын бэлэн байдлыг хангах тухай”, “Томуугийн шинэ вирусын халдвараас сэргийлэх талаар хийх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх тухай”, “Томуугийн А хүрээний H1N1 шинэ вирусын халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” бодлогын баримт бичгүүдийг боловсруулан гаргаж, 17 сум, 5 тосгон, 7 өрхийн эмнэлэгт хүргүүлж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллалаа. Томуугийн А хүрээний H1N1 шинэ вирусийн дэгдэлт улс орон даяар гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамж гарган шуурхай арга хэмжээг зохион байгуулж, ариутгал халдваргүйжүүлэлт, үзлэг тандалт хийх, урьдчилан сэргийлэх, эмийн нөөц бүрдүүлэлтэнд зориулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс нийт 25680.0	100	50










			<p>хоолны хэрэгсэл зэрэг 5 багцын 42 нэрийн иж бүрэн тавилга тоног төхөөрөмж, “Тогтвортой амьжиргаа” төслөөс Сайхан сумын цэцэрлэгийг 2.0 сая төгрөгийн, Цагааннуур сумын цэцэрлэгийг 4.9 сая төгрөгийн, Орхонтуул сумын цэцэрлэгийг 3.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ширээ сандлаар хангаж, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байсан хөдөө орон нутгийн хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нэмж хамруулах боломжийг бүрдүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй 75 хүүхдийг цэцэрлэгт хамруулаад байна.</p> <p>“Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн дагуу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2009 оноос эхлэн төрөөс хариуцах болсноор сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, улсын төсөвт 30 цэцэрлэгт 4181, хувийн хэвшлийн 3 цэцэрлэгт 185, сувиллын яслид 24, албан газрын төсөвт цэцэрлэгт 512, хувилбарт сургалтанд 1019 хүүхэд, нийт 5921 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, хамран сургалт 83.3 хувь, цэцэрлэгийн үндсэн бүлгийн хамран сургалт 70.1 хувьд хүрч, СӨБ-ын хамралтыг улсын дундажтай /76.6 хувь/ харьцуулахад 6.7 хувиар, үндсэн бүлгийн хамран сургалтыг улсын дундажтай /58.6 хувь/ харьцуулахад 11.5 хувиар ахисан үзүүлэлттэй байна.</p> <p style="text-align: center;"><b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХАМРАН СУРГАЛТ</b></p>  <table border="1" data-bbox="936 764 1755 1117"> <thead> <tr> <th>Хугацаа</th> <th>сөб-ын хамралт (%)</th> <th>цэцэрлэгийн хамралт (%)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2005-2006</td> <td>54.9</td> <td>45.6</td> </tr> <tr> <td>2006-2007</td> <td>56.5</td> <td>46.5</td> </tr> <tr> <td>2007-2008</td> <td>62.5</td> <td>52.2</td> </tr> <tr> <td>2008-2009</td> <td>65.8</td> <td>56.5</td> </tr> <tr> <td>2009-2010</td> <td>83.3</td> <td>70.1</td> </tr> </tbody> </table>	Хугацаа	сөб-ын хамралт (%)	цэцэрлэгийн хамралт (%)	2005-2006	54.9	45.6	2006-2007	56.5	46.5	2007-2008	62.5	52.2	2008-2009	65.8	56.5	2009-2010	83.3	70.1		
Хугацаа	сөб-ын хамралт (%)	цэцэрлэгийн хамралт (%)																					
2005-2006	54.9	45.6																					
2006-2007	56.5	46.5																					
2007-2008	62.5	52.2																					
2008-2009	65.8	56.5																					
2009-2010	83.3	70.1																					
10	1.2.3	<p>Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх, багш нарыг сургах, давтан бэлтгэх, сурагчдыг сурах бичгээр хангах, шинэ тогтолцоонд шилжихэд нийгмийн сэтгэл зүйг бэлтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах зэрэг олон арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Үр дүнд түргэн хүргэх санаачилгын түншлэл” төслөөс 6 настанд хичээл заах, тэдэнтэй ажиллах арга зүйн сургалтыг зохион байгуулж, 58 багш хамрагдаж, аймгийн хэмжээнд 6 настны бүх анги 30 төрлийн сургалтын</p>	100	70																		



			<p>хэрэглэгдэхүүн, тоглоомоор хангагдлаа. Улсын төсөв, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ерөнхий боловсролын сургуулийн 6 настай 1-р ангийн бүх бүлгийг ширээ сандлаар хангаж, сурагчдын сурч боловсрох ая тухтай орчныг бүрдүүллээ. 6 настай 1-р ангийн биеийн тамирын хичээлийн дасгал хөдөлгөөний цахим сурах бичгийг бүх сургуулиудад түгээлээ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлагдсан ерөнхий боловсролын стандарт, 11 ба 12 жилийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг мөрдөн ажиллаж, 2008-2009 оны хичээлийн жилд бага боловсролыг 946, суурь боловсролыг 1807, бүрэн дунд боловсролыг 1651 суралцагч эзэмшлээ. 9-р ангийн 1918, 11-р ангийн 1762 төгсөгчдөд боловсролын баримт бичиг олголоо. Улсын оны аваргаар 1 багш шалгарч, сурагчдын авъяас, чадварыг хөгжүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг улсын төрөлжсөн олимпиадад 11 сурагч, 3 багш амжилттай оролцож, эхний 5-н байрт шалгарсан амжилтыг үзүүллээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хандиваар бүтээгдсэн дэлхийн шилдэг 50 бүтээлийн ном, хүүхдийн уран зохиолын 5 ботийг бүх сургуулиудад хүргүүлж, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “READ” төслөөс бүх бага ангийг уншлагын номын сан, тавиураар хангаж, ангийн номын сантай ажиллах, ашиглах чадварыг дээшлүүлэх арга зүйн сургалтыг Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулж, захирал, сургалтын менежер, бага ангийн багш, номын санчдыг хамруулан, гарын авлагаар бүрэн хангалаа. Аймгийн хэмжээнд сурах бичгийн хангалт 61.4 хувьтай байна. Сүхбаатар сумын 4-р багт 1042 хүүхдийн хүчин чадалтай бүрэн дунд сургууль шинээр барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, сумдын ерөнхий боловсролын сургуулиудын гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалттай анги бүлгийн тоог нэмэгдүүлж, Мандал сумын 2-р сургуульд орос хэл, англи хэл, математик, физик, хими, мэдээлэл зүйн хичээлээр, Мандал сумын 3-р сургууль, Сүхбаатар сумын 1, 4-р сургуулийн математик, химийн хичээлээр гүнзгийрүүлсэн сургалт Мандал, Сүхбаатар сумдын хувийн хэвшлийн цэцэрлэгт англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтыг явуулж, түүнд 50 хүүхэд хамрагдлаа. 2007-2008 оны хичээлийн жилээс эхлэн Буриадын Хиагтын районы сургууль, цэцэрлэг Сүхбаатар сумын 4-р сургууль, 3-р цэцэрлэгт орос хэлний сургалттай анги бүлгийг нээн, хамтран ажиллаж байгаа нь сурагчдын сурч, хөгжихөд сайнаар нөлөөлж байна. Гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт явуулах кабинет, ном, сургалтын хэрэглэгдэхүүнийг хангасан байдлыг үндэслэн Боловсрол соёлын газраас гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг нь баталж, дүгнэлт гарган Сүхбаатар сумын 4-р сургуульд байгалийн ухааны, Мандал сумын 2-р сургуульд техник технологийн хичээлээр гүнзгийрүүлсэн сургалт, Сүхбаатар</p>		
--	--	--	---	--	--

сумын 1-р сургуульд англи хэл, волейболын, 2-р сургуульд урлаг, спортын мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд техникийн төрлөөр сургалтыг амжилттай явуулснаар сургалтын стандарт хангалт улсын дунджаас 8.8 хувиар, 2007-2008 оныхтой харьцуулахад 0.6 хувиар ахисан үзүүлэлттэй байна.


#### СТАНДАРТ ХАНГАЛТ



Дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд “Тогтвортой амьжиргаа” төслөөс Хүдэр сумын сургуулийн дотуур байранд 9.8 сая, Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байранд 6.5 сая, Хушаат сумын сургуулийн дотуур байранд 5.5 сая, Баянгол сумын сургуулийн дотуур байранд 9.7 сая төгрөгийн хатуу эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжөөр хангаж, суралцагчдын амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэн, улсын төсвийн 47.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Түшиг сумын сургуулийн дотуур байрны их засвар хийж, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, аймгийн төсвийн 225.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шаамар суманд 75 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр, улсын төсвийн 67.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хушаат суманд 50 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны өргөтгөл, сум хөгжүүлэх сангийн 54.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянгол сумын сургуулийн дотуур байрны өргөтгөлийг шинээр барьж ашиглалтанд оруулан орны тоог нэмэгдүүлснээр малчдын хүүхдийн хамрагдах хүрээ нэмэгдэж, сургууль завсардалт буурахад эерэг нөлөө үзүүлж байна. Аймгийн хэмжээнд 19 дотуур байранд 1421 хүүхэд амьдарч, дотуур байрны хамралт 93.1 хувьтай байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад 3.3 хувиар ахисан үзүүлэлттэй байна. 2009-2010 оны хичээлийн жилд улсын төсөвт 32, хувийн хэвшлийн 3 сургуульд 19429 суралцагч суралцаж, хамран сургалт 98.4 хувьд хүрч, өмнөх оныхоос 0.2 хувиар нэмэгдсэн байна.

#### СУУРЬ БОЛОВСРОЛЫН ХАМРАН СУРГАЛТ


			<table border="1"> <caption>Төвлөрсөн сургалт (Төгсөгчдийн хувь)</caption> <thead> <tr> <th>Хугацаа</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2005-2006</td> <td>97.90%</td> </tr> <tr> <td>2006-2007</td> <td>98.00%</td> </tr> <tr> <td>2007-2008</td> <td>98.20%</td> </tr> <tr> <td>2008-2009</td> <td>98.40%</td> </tr> <tr> <td>2009-2010</td> <td>98.40%</td> </tr> </tbody> </table>	Хугацаа	Хувь	2005-2006	97.90%	2006-2007	98.00%	2007-2008	98.20%	2008-2009	98.40%	2009-2010	98.40%		
Хугацаа	Хувь																
2005-2006	97.90%																
2006-2007	98.00%																
2007-2008	98.20%																
2008-2009	98.40%																
2009-2010	98.40%																
11	1.2.4	Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангаж, тэдний мэргэшлийг дээшлүүлнэ.	<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дутагдалтай багшийн судалгааг мэргэжил тус бүрээр нь гарган, ажил идэвхтэй хайж байгаа болон шинээр төгссөн багш нарыг нөөцөнд бүртгэн ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлснээр мэргэжлийн багшийн хангамж 97.6 хувьтай боллоо. Мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь 48.6 хувьд хүрч, өмнөх оныхоос 3.1 хувиар нэмэгдлээ. Сургууль, цэцэрлэгийн багш удирдах ажилтны хамтын ажиллагааг өргөжүүлэн заах арга, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр аймгийн нийт сургуулийг Сүхбаатар, Мандал, Ерөө, Сайхан, Цагааннуур 5 бүсэд хувааж, бүсийн төвийн сургуулиудад “Багш хөгжлийн төв”-ийг байгуулж, үйл ажиллагаа нь тогтмолжлоо. “Тогтвортой амьжиргаа” төслөөс Бугант тосгоны цэцэрлэгийн “Багш хөгжлийн төв”-ийг 5.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангалаа. “Багш хөгжлийн төв”-ийг түшиглэн багш нарын дунд сургалт семинар, сурган хүмүүжүүлэх уншлага, ур чадварын уралдаан, үзүүлэх ажил, олимпиад, спорт урлагийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулснаар бүсийн сургууль, цэцэрлэгүүдийн багш нар ажлын байрандаа тасралтгүй мэргэжлээ дээшлүүлэх, харилцан туршлага судлах, суралцах, сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх сургалтын арга барилыг төлөвшүүлэх боломж бүрдэж, сургуулийн хөгжилд ахиц гарч сургалтын чанарт сайнаар нөлөөлж байна. Сайн дурын мэргэжилтэн Сүхбаатар сумын 12 жилийн 2, 4, Сайхан сумын сургуулиудад ажиллаж үзүүлэх сургууль, туршлага солилцох ажлуудыг зохион байгууллаа. Багш нарт зориулсан сургалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Боловсролын хүрээлэн, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, “Гурван-эрдэнэ” Багшийн Дээд сургуультай хамтран зохион байгуулж, төвлөрсөн сургалтанд 1463, орон нутгийн төрөлжсөн сургалтанд 2770 багш, удирдах ажилтан хамрагдлаа.</p> <p style="text-align: center;"><b>ТӨВЛӨРСӨН СУРГАЛТ</b></p>	100	50												

			 <p><b>МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ</b></p>		
12	1.2.5	Бичиг үсэгт тайлагдалтын түвшинг ахиулна.	<p>Албан бус боловсролын бүтэц, тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд сум бүхэнд Засаг даргаар удирдуулсан зөвлөл ажиллаж, албан бус боловсролын 20 гэгээрэл төв үйл ажиллагаа явуулан, түүнд 24 багш ажиллаж, сургууль завсардагчид болон насанд хүрэгчид, иргэдэд боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Сургууль завсардсан болон бүрэн бус дунд сургууль төгссөн 191 хүүхдүүдийг эчнээ, оройн сургалтанд үргэлжлүүлэн сургаж, боловсрол нөхөн олгож байна. Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн Амын Сантай хамтран Баруунбүрэн сумын 25 хүүхдэд бичиг үсгийн боловсрол олгох зуны сургалтыг зохион байгууллаа. Иргэдийн боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх чиглэлээр амьдрах ухааны, мэдээлэл, хэлний чиглэлээр 12 төрлийн сургалтыг явуулж, 6490 хүн хамрагдлаа. Баруунбүрэн сумын Гэгээрэл төвөөс хийдийн лам хүүхдүүдэд боловсрол нөхөн эзэмшихэд нь туслан дүйцсэн хөтөлбөрийн сургалтандаа жил бүр 20 гаруй хүүхдийг хамруулан амжилттай сургаж байна. Хүн амын бичиг үсгийн боловсролын түвшинг дээшлүүлэх чиглэлээр зуны улиралд бичиг үсгийн сургалтуудыг тогтмол явуулснаар бичиг үсэг үл мэдэгчдийн тоо 198 болж, өнгөрсөн жилийнхээс 32.4 хувиар буурсан үр дүнтэй байна.</p>	100	30
13	1.2.6	Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангана.	<p>Сургуулийн номын сангаар дамжуулан ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн бага ангийн сурагчдын 100 хувь, 11 жилийн сургуулийн бага ангийн сурагчдын 80 хувь, дунд, ахлах ангийн сурагчдын 40 хүртэл хувийг 2009 оны хичээлийн жилд шинээр зохиосон болон дахин хэвлэсэн 25 нэр төрлийн 32636 ш сурах</p>	100	30

			бичгээр хангалаа. Аймгийн хэмжээнд сурах бичгийн хангалт 61.4 хувьтай байна.																	
14	1.2.7	“Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлнэ.	<p>“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, ариун цэврийн нөхцөл байдлыг судлан дүгнэлт гаргах ажлын хэсэг 16 сургуулийн үйл ажиллагаатай газар дээр танилцан зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Сургууль бүр 7-14 хоногт анги танхим, гал тогоо, ариун цэврийн өрөөнд ариутгал хийж, “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс Баруунбүрэн, Орхонтуул сумдын сургуульд 10.0 сая төгрөгийн, Сайхан сумын сургуульд 4.0 сая төгрөгийн, “Үр дүнд түргэн хүргэх санаачилгын түншлэл” төслөөс Хэрх тосгоны сургуульд 8.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан гал тогооны тоног, төхөөрөмж нийлүүлснээр үдийн хоолоор хангах боломжтой боллоо.</p> <p align="center"><b>“ҮДИЙН ЦАЙ” ХӨТӨЛБӨР</b></p> <table border="1"> <thead> <tr> <th>Төвлөлт</th> <th>Хамрагдал</th> <th>Санхүүжилт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2007.06</td> <td>6640</td> <td>19287</td> </tr> <tr> <td>2008.06</td> <td>9185</td> <td>317547</td> </tr> <tr> <td>2009.06</td> <td>9030</td> <td>314244</td> </tr> <tr> <td>2009.12</td> <td>9961</td> <td>544445.1</td> </tr> </tbody> </table> <p>Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн 9961 хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж, 544.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ.</p>	Төвлөлт	Хамрагдал	Санхүүжилт	2007.06	6640	19287	2008.06	9185	317547	2009.06	9030	314244	2009.12	9961	544445.1	100	50
Төвлөлт	Хамрагдал	Санхүүжилт																		
2007.06	6640	19287																		
2008.06	9185	317547																		
2009.06	9030	314244																		
2009.12	9961	544445.1																		
15	1.2.12	Мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн сургалтын бааз, лабораториор хангаж, технологийн шинэчлэл хийнэ.	Сүхбаатар, Шаамар, Сант сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэж, тэдэнд мэргэжил эзэмшүүлэхийн зэрэгцээ бүрэн дунд боловсролыг олгож байна. Авто машин, трактор, фермер, үсчин, гоо засалч, нарийн мужаан, нийтийн хоол, нарийн боов, оёдолчин, эсгүүрчин, эсгий урлал, хивсчин, барилгын өргөн мэргэжил, цахилгаанчин, компьютер засвар зэрэг мэргэжлүүдээр элсэлт авч, энэ хичээлийн жилд Сүхбаатар, Шаамар, Сант суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1320 суралцагч суралцаж, 35 сургалтын лаборатори, дадлагын ажлын өрөөнд суудлын тоо 875 болж, сургалт дадлагын орчин сайжирч, үйлчилгээний хүрээ өргөжиж байна. Мандал суманд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг шинээр нээж, 6 мэргэжлээр 12 ангид 330 оюутан элсүүлэн суралцуулж, 67.9 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Орон нутгийн төсвийн 200.0 мянган төгрөгөөр Сант сумын сургуулийн их засварын зураг төслийг	100	50															



			хийлгэж, улсын төсвийн 5.1 сая төгрөгөөр тавилга, спорт хэрэгсэл, үндэсний хөгжим, Мандал сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 16.1 сая төгрөгөөр иж бүрэн компьютер, хөгжим, тавилгаар хангаж, сурах таатай орчинг бүрдүүллээ. Сүхбаатар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн бизнес эрхлэгчид, эрхлэхийг хүсэгчдийг дэмжих зорилго бүхий “Бизнес-Инкубатор төв”-ийг байгуулан үйл ажиллагаа нь тогтмолжил 9 суманд ажиллан 300 гаруй хүнд зөвлөгөө өгч сургалт явуулсан байна. Сант сумын Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 16 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр, Шаамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 18 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварын оношилгоо, мужааны кабинет байгуулан, сургалтын орчноо сайжруулсан байна. Цагааннуур, Ерөө, Баянгол, Мандал сумын 1, Сант, Сайхан, Сүхбаатар сумын 1, 4-р сургуулиуд мэргэжлийн боловсрол олгох төсөлд хамрагдаж, сургалтын тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүнээр хангагдсан нь ерөнхий боловсролын сургуулиуд мэргэжлийн боловсрол олгох түр сургалт, курс, дугуйлан хичээллүүлэх боломж бүрдэн академик болон прагматик хэлбэрийг хослуулан сургалтаа явуулах боломжтой боллоо.		
16	1.2.19	Хичээлийн болон дотуур байр, номын сан, биеийн тамирын заал барих, өргөтгөх, сургуулийг компьютержүүлэх, интернэтэд холбох зэргээр чанартай боловсролын орчин бүрдүүлэхэд өөрчлөлт гаргана.	Мандал суманд 640 хүүхдийн хүчин чадалтай ерөнхий боловсролын сургууль шинээр барихаар төлөвлөгдөн бэлтгэл ажил хангагдаж, шадар сайдын багцын төсөвт суулгууллаа. Улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг сумын сургуулийн өргөтгөл, 206.0 сая төгрөгөөр Ерөө суманд спортын зал шинээр барьж, 30.0 сая төгрөгөөр Орхон сумын сургуулийн хичээлийн байрны барилгын их засвар, 49.5 сая төгрөгөөр Сүхбаатар сумын 4-р сургуулийн бага сургуулийн хичээлийн байрны барилгын их засвар, 29.8 сая төгрөгөөр Шаамар сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засвар, 88.3 сая төгрөгөөр Дулаанхан тосгоны сургуулийн дээврийн засвар, орон нутгийн төсвийн 5.6 сая төгрөгийн санхүүжилтээр Сүхбаатар сумын 1-р багт 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга шинээр барих, барилгын зураг төслийг хийлгэж, Дэлхийн Зөн Олон улсын байгуулага, орон нутгийн төсвийн 110.0 сая төгрөгөөр Шаамар сумын сургуулийн дотуур байрыг шинээр барьж, 10.6 сая төгрөгөөр Түшиг сумын сургуулийн дээврийн засвар, 46.7 сая төгрөгөөр Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн барилгын дээвэр, 8.6 сая төгрөгөөр Мандал сумын 2-р сургуулийн барилгын дээвэр, 15.0 сая төгрөгөөр Сүхбаатар сумын 2-р сургуулийн дулааны шугамыг засварлаж, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Үр дүнд түргэн хүргэх санаачилгын түншлэл” төслийн 160.0 сая төгрөгийн санхүүжилтээр Сүхбаатар сумын 5-р сургуулийн хичээлийн байр, Азийн хөгжлийн банкны 130.0	100	50

			<p>сая төгрөгийн санхүүжилтээр Мандал сумын Түнхэл тосгоны сургуулийн иж бүрэн засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Сүхбаатар суманд 50 хүүхдийн хүчин чадалтай хувийн цэцэрлэг шинээр ашиглалтанд орж, Европын Холбооны болон Их Британий Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр “Сургуулийн өмнөх болон, бага боловсролын чанарыг сайжруулах нь” төслөөс Мандал сумын 1-р сургууль, Хүдэр, Сүхбаатар сумын 6-р сургууль, Орхон сумын сургуулиудад 28.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бие засах газар, орц, гарц, ариун цэврийн ерөөг тохижууллаа. “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс Ерөө сумын цэцэрлэгт 4.2 сая, Бугант тосгоны сургуульд 6.0 сая төгрөгийн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, Зүүнбүрэн сумын сургуульд 4.0 сая, Сүхбаатар сумын 3-р сургуульд 2.1 сая, 6-р сургуульд 1.8 сая төгрөгийн спортын талбайн, Түшиг сумын сургуулийн биеийн тамирын залны засвар, тохижилтонд 9.0 сая, Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн гадаад тохижилтонд 3.2 сая төгрөгийг санхүүжүүлээ. Цэцэрлэгийн 90 хувь нь тоглоомын талбайгаа сэргээн засварлаж, тоглоом, наадгай шинээр хийлээ. Сургууль бүр өөрсдийн нөөц боллоцонд тулгуурлан биеийн тамирын талбайг засварлаж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалаа. Сурагчдад мэдээлэл зүйн боловсролыг чанартай эзэмшүүлэх, мэдээллийн технологийг сургалтанд хэрэглэх зорилгоор улс, орон нутгийн төсөв, УИХ-ын гишүүд, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, хандивлагч байгууллагуудын тусламжтайгаар компьютерээр бүрэн хангах ажлыг үе шаттайгаар хийж байна. Сургууль, цэцэрлэгүүдийн компьютерийн хүрэлцээ, хангамж сайжирч, 1243 компьютер ашиглагдаж байгаа нь 2005 оныхоос 3.5 дахин нэмэгдээд байна. Аймгийн хэмжээнд 18 сургууль интернетэд холбогдлоо. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Үр дүнд түргэн хүргэх санаачилгын түншлэл” төслөөс бүх сургуулиудыг явуулын компьютерийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр ханган, мэдээлэл холбооны технологийг ашиглаж, 6 сургууль онлайнаар англи хэлний сургалтыг явуулж, ахлах ангийн сурагчид хамрагдаж байна. “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар сумын 3-р сургуулийн 2-5-р ангийн сурагчид 186 ширхэг компьютертай болсон нь багш, сурагчид өдөр тутмын хичээл, сургалтын үйл ажиллагаандаа мэдээллийн технологийг өргөн ашиглаж, багш нар харилцан туршлага судлах, заах арга, ур чадвар, мэдлэг боловсролоо бие даан дээшлүүлэх боломж бүрдлээ. Улсын төсвийн 3.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ерөө сумын Бугант тосгоны сургуульд иж бүрэн компьютер, “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс Баруунбүрэн сумын цэцэрлэг, Ерөө, Орхон, Сант сумдын сургуульд иж бүрэн компьютер, Сайхан сумын сургуульд 2.0 сая төгрөгийн хөдөлмөрийн хичээлийн тоног төхөөрөмжийг нийлүүллээ. Суралцагчдыг электрон шуудангийн хаягтай болгох зорилгоор 2009</p>		
--	--	--	---	--	--

			<p>оны элсэлтийн ерөнхий шалгалтанд орох 1692 хүүхдийг онлайн бүртгэлд бүрэн хамруулснаар их дээд сургуульд шинээр элсэгчид бүгд цахим шуудангийн хаяг, 1-р сургууль цахим хуудастай болж, сургуулиа сурталчлах, мэдээ мэдээллээр хангах ажлыг хийж хэвшээд байна. Европын Холбооны Комисс, Их Британий Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр “Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын чанарыг сайжруулах нь” төслөөс бүх цэцэрлэгүүдэд дүрслэх урлагийн хичээлийн иж бүрэн үзүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах гарын авлага, номоор хангалаа. “Хүүхдэд ээлтэй сургууль” сургалтын хөтөлбөр болон бусад сургалтын материалыг CD хэлбэрээр боловсруулж сургуулиудад хүргүүлээ.</p> <p style="text-align: center;"><b>КОМПЬЮТЕРИЙН ТОО</b></p>  <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th>Year</th> <th>Number of Computers</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2005</td> <td>354</td> </tr> <tr> <td>2006</td> <td>705</td> </tr> <tr> <td>2007</td> <td>843</td> </tr> <tr> <td>2008</td> <td>944</td> </tr> <tr> <td>2009</td> <td>1243</td> </tr> </tbody> </table>	Year	Number of Computers	2005	354	2006	705	2007	843	2008	944	2009	1243		
Year	Number of Computers																
2005	354																
2006	705																
2007	843																
2008	944																
2009	1243																
17	1.2.22	Соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгож, “Соёл, урлагийг 2009-2012 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлнэ.	Соёл, урлагийн бодлогыг хөдөө орон нутаг рүү чиглүүлж, соёлын үйлчилгээг сум, багийн иргэдэд ойртуулан тэгш хүртээмжтэй болгох, урлагийн бүх төрөл, түүний дотор үндэсний уламжлалт урлаг, ёс заншил, түүх соёлын дурсгалт зүйлс, утга соёлын өвийг дээдлэн үр удамдаа үлдээх, соёлын талаарх орчин үеийн хандлага, үзэл баримтлалыг олон нийтэд ойлгуулан таниулах, түүнийг нийгэм эдийн засгийн бусад салбартай нягт холбох зорилгоор соёл урлагийг 2009–2012 онд хөгжүүлэх бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан батлуулахад бэлэн болгоод байна.	50	30												
18	1.2.24	Орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий хамгаалалтын хэрэгслээр хангах, менежментийг нь боловсронгуй болгож улмаар түүх, соёлын үнэт зүйлс, музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна	Мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэх, утга соёл өвийн санг баяжуулах, дүрс бичлэгээр баримтжуулан хадгалах, шинэчлэх зорилгоор музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах нөхцөлийг судлан дохиоллын систем ажиллуулж, үзмэр хадгалалт хамгаалалтыг сайжрууллаа. 2009 онд Зүүнбүрэн, Орхон, Хушаат сумд, Хэрх тосгонд “Орон нутаг судлах танхим” байгуулж, үйл ажиллагаа нь тогтмолжсон бөгөөд аймгийн хэмжээнд нийт 154 төрлийн үзмэрээр сан хөмрөгөө баяжууллаа. Баруунбүрэн суманд болсон “Амарбаясгалант хийд-орон нутаг судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын үеэр сумын соёлын төвийн орон нутаг	100	30												



			судлах танхимууд үзэсгэлэн зохион байгуулж гадаад, дотоодын жуулчдад орон нутгаа сурталчиллаа.		
19	1.2.25	Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлнэ.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 20 соёлын төв 839 арга хэмжээнд давхардсан тоогоор 140123 хүнийг хамруулсан байна. Соёлын төвүүдийн 88 хувь нь компьютерээр хангагдсан бөгөөд 2009 онд Баруунбүрэн, Баянгол, Зүүнбүрэн, Түшиг, Ерөө сум, Бугант тосгоны соёлын төвийн их болон урсгал засвар, техник хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмжинд улс болон орон нутгийн төсвөөс 206 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас 68.758.315 төгрөг, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөс 15.310.000 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламжаар 3.160.000 төгрөг, соёлын төвийн төсвөөр 670.000 төгрөг нийт 293.898.315 төгрөгийн, Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт орших “Амарбаясгалант” хийдэд АНУ-ын элчин сайдын яамнаас 86.200 долларын хөрөнгө оруулалт хийгдлээ.	100	50
20	1.2.27	Сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлнэ.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 33 номын сан 45171 хүнд 271600 ширхэг номоор үйлчилж, номын фондын 60 гаруй хувийг шинэчилсэн бүртгэлд бүртгэлээ. Номын сангууд 29.158.028.19 төгрөгийн үнэ бүхий 4305 шинэ номоор сан хөмрөгөө баяжуулж, 11183 ширхэг номыг сэргээн засварлаж, Баянгол, Зүүнбүрэн, Цагааннуур, Орхонтуул сум, Бугант тосгоны соёлын төвд уншлагын танхим шинээр байгуулах, Мандал сумын нийтийн номын санг тохижуулахад 10 гаруй сая төгрөгийг зарцууллаа. 2009 онд 33539 ном олгож, 17076 уншигчдад үйлчилсэн байна.	100	50
<b>1.3.Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого</b>					
21	1.3.1	Ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн идэвх, санаачилгыг дэмжин бизнес эрхлэх орчныг бүрдүүлэх, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулна	Аймгийн хэмжээнд ядуурлаас гаргах 466 өрхийг сонгон авч, дэлгэрэнгүй судалгааг гарган, мэдээллийн сан бий болголоо. Хамрагдсан өрхийн 31.4 хувь нь ядуурлаас гарах арга хэмжээнд хамрагдаж, өрхүүдийн амьжиргаа нь дээшиллээ. Сонгогдсон өрхийн 117 иргэнийг нийтийг хамарсан ажилд, 39 иргэнийг мэргэжил болон ур чадвар олгох сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 12800.0 мянган төгрөгийг зарцууллаа. Жавхлант, Мандал, Алтанбулаг, Орхон, Сайхан зэрэг сумдад 117 хүнийг тохижилт, зам засвар, цэцэрлэгжүүлэлт, ногоон төгөл, суулгац зэрэг нийтийг хамарсан ажилд хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 7788.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	100	30
22	1.3.2	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрхийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 60.0 мянгаас дээш ажлын байр бий болгоно.	Шинэ ажлын байрыг бүртгэх <a href="http://www.ejob.mn">www.ejob.mn</a> цахим хуудсанд сар бүр мэдээ, мэдээллийг байрлуулснаар ажилгүй, ажил хайж байгаа иргэд мэдээллийг дэлгэрэнгүй авах нөхцөл бүрдэж, 2009 онд нийт 2222 шинэ ажлын байр бий болж, 2009 оны төлөвлөгөө 100 хувь биелсэн. Шинэ ажлын байрны 1844 хүн байнгын 378 хүн түр ажлын байраар хангагдлаа. Шинэ ажлын байрны 11.8 хувь нь төсөвт байгууллагад, 88.2 хувь нь хувийн хэвшилд бий болсон байна.	100	30

23	1.3.11	Ажилгүйдлийн түвшинг 2012 оны эцэст 2,5 хувьд хүргэж бууруулна.	<p>Ажил олгогчоос ирүүлсэн 2029 ажлын байранд 2029 хүнийг ажилд зуучлан хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж буй иргэдийн тоо 1120 болж, эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулбал ажилгүйдлийн түвшин 2.8 хувьтай боллоо. 2009 онд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо урьд оноос 14.5 хувиар нэмэгдсэн байна.</p> 	100	50
24	1.3.15	Өрх бүрээс мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн нэгээс доошгүй хүнийг мэргэжил эзэмшүүлж, ажилтай болгоно.	<p>Нийт 682 ажил, мэргэжилгүй иргэдийг 15 төрлийн мэргэжил, ур чадвар олгох сургалтанд хамруулж, 68.7 хувийг ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 66197.5 мянган төгрөг зарцууллаа.</p> 	100	30
<b>1.4.Нийгмийн хамгааллын бодлого</b>					
25	1.4.1	Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, төрөл, хэлбэрийг оновчтой болгоно.	<p>Монгол Улсын Засгийн газраас “Үйлдвэржилтийг дэмжих жил” болгон зарласан жилийн ажлын хүрээнд иргэдэд мэргэжил олгох, шинээр ажлын байранд зуучлах Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих замаар амьжиргааг дээшлүүлэх, халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээг үзүүлэх зорилго тавин, халамжийн сан болон хүүхдийн мөнгөн сан, хүүхэд хөгжил сангаас тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгох, хөнгөлөлт үйлчилгээг зохих дүрэм журмыг баримтлан оновчтой үзүүлэхэд анхаарч ажиллалаа. Халамжийн сан болон хүүхдийн мөнгөн сан, хүүхэд хөгжил сангаас нийт 55726 хүнд 8544495.6 мянган төгрөгийг зарцууллаа. Мөн харьяалалгүй</p>	100	50

			ахмадуудыг харъяалалтай болгох ажлыг зохион байгуулж 1500 ахмадад сар шинийн хүндэтгэл үзүүлсэн. Сайхан, Мандал суманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор өдөрлөг, үзэсгэлэн яармаг зохион байгуулж, ажилд зуучлах арга хэмжээг авч, 120 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан байна.		
26	1.4.15	Хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын дадал олгох, аливаа хорт, муу зуршлаас ангид байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгох чиглэлээр гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжинэ.	Хүүхэд өсвөр үеийнхнийг тодорхой зорилго тэмүүлэлтэй амьдрах хүмүүжилтэй болгох, эрүүл амьдралын зөв дадлыг хэвшүүлэх, үр хүүхдийнхээ төлөө эцэг эх, иргэний хүлээх хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар холбогдох байгууллагуудтай хамтран “Ирээдүйгээ зөв төлөвшүүлье” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэн 10000 гаруй хүүхэд болон насанд хүрэгчдэд үйлчиллээ. Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөний үр дүнд өсвөрийн цагдаа бүлгэмийн үйл ажиллагаа идэвхжиж, эрүүл мэндийн анхан шатны үзлэг, сургуульд анги хамт олноороо хамрагдсанаас гадна иргэний бүртгэл мэдээллийн улсын бүртгэлд байхгүй 130 хүүхэд, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй 4 сумын 230 хүүхдийг аяны хугацаанд даатгалд хамруулах, бичиг баримттай болгох арга хэмжээг авлаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн “Хүүхэд бүхэн жаргалтай байг” өдөрлөгийг аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулж, 3-17 насны 23 хүүхэд эцэг эхийн хамт хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг шинэчлэн 516 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүртгэгдлээ. Алтанбулаг суманд ахлах ангийн багш сурагчдын дунд “Хүүхэд гэр бүл” хэлэлцүүлэг, албан бус боловсролын Гэгээрэл төвийн сурагчид болон төгсөх ангийн хүүхдүүдийн дунд мэргэжил сонголт, харилцааны талаар сургалт зохион байгуулсан байна. Хүүхэд өсвөр үеийнхнийг зөв иргэн болгон төлөвшүүлэх, гэмт хэрэг, зөрчилгүй анги, хамт олон болгох үүднээс Дэлхийн Зөн Монгол Олон улсын байгууллагын Сэлэнгэ Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлтээр “Итгэлцэл”-ийн хуудас хэвлүүлэн ерөнхий боловсролын 34 сургуулийн 10240 хүүхдэд тараалаа.	100	50
<b>1.5. Хүн амын бодлого</b>					
27	1.5.5	Хөдөлмөрийн чадвар бүхий ахмадуудад тохирсон ажлын байр бий болгоход тусламж, дэмжлэг үзүүлнэ.	Сант суманд “Сүү цагаан идээ боловсруулах” сургалтанд сумын 21 ахмадыг хамруулан сургаж 1050.0 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа.	70	30
28	1.5.6	Ахмад настны эрүүл мэндийг сайжруулахад зориулан эмнэлэг, сувиллын газар, ахмадын ордон байгуулна.	Аймгийн 17 сум, 5 тосгонд ахмадын чийрэгжүүлэлтийн танхимыг байгуулж, тус бүр 1.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тохижуулан ахмад настнуудад биеийн тамираар хичээллэх, эрүүл мэндээ	100	50

			хамгаалах боломж нөхцөлийг бүрдүүлж өглөө. Сүхбаатар, Баянгол, Мандал сумын ахмадын сувилалд нийт 689 гаруй ахмадыг хамруулж, эмийн болон бариа засал, физик эмчилгээ үйлчилгээгээр үйлчилсэн. Сүхбаатар суманд ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх сувиллын газрыг 2010 онд барьж ашиглалтанд оруулахаар хөрөнгийг улсын төсөвт тусгууллаа.		
29	1.5.7	Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцийг бүрэн хэрэгжүүлж мөрдүүлнэ.	Нэгдсэн үндэсний байгууллагын “Хүүхдийн эрхийн тухай” конвенц батлагдсаны 20 жилийн ойг угтаж хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн албатай хамтран хууль, эрх зүйн мэдээ мэдээлэл, яриа таниулгыг 540 хүүхдэд хийж, бар, тоглоомын газар, зочид буудал, биллярдын газруудаар хяналт шалгалт хийж, зөрчлийг илрүүлэн зохих шатны байгууллагад шилжүүллээ. Насанд хүрээгүй хүмүүсээс гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа Монгол Улсын Эрүүгийн хэргийн хуулийн 62, 69-р зүйлд зааснаар анх удаа гэмт хэрэг үйлдсэн 5 хүүхдэд ял хойшлуулах хүсэлтийг шүүхийн байгууллагад хандан гаргаж, эрх зүйн үйлчилгээг үзүүллээ. Хараа хяналт султай хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг эх асран хамгаалагч нартай нь биечилж уулзан, тулгамдаж байгаа асуудлын талаар ярилцаж, заавар зөвлөгөө өгөх үйлчилгээг тогтмол зохион байгуулж, 50 гаруй хүүхдэд үйлчиллээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарилгаар өршөөлөөр суллагдсан Мандал сумын 11, Сүхбаатар сумын 1, Бугант тосгоны 1 нийт 13 хүүхдийг хүлээн авч, хүүхэд тус бүр дээр хяналтын карт нээж, нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлж, хорихоос суллагдсан насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчил болон дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн харилцаанд зөв оролцох, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах, хүмүүжил олгох зорилгоор “Хамтдаа” уулзалт сургалтыг Мандал сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газрын хүүхдийн албатай хамтран зохион байгууллаа. Уулзалт өдөрлөгт нийт 40 хүн оролцон сургалтанд хамрагдаж, хүүхэд хамгааллын мэргэжилтэн зөвлөгөө өгч ажиллалаа. Эдгээр хүүхдүүдийн 2 хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд, 1 хүүхэд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байна.	100	50
30	1.5.8	Асран халамжлах хүнгүй, бүтэн болон хагас өнчин, хараа хяналтгүй хүүхдийг төрийн анхаарал халамжид авч эрхийг нь хамгаалах, гэр бүлийн орчинд өсч хүмүүжих бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлнэ.	Хүүхдийг нийгэмшүүлэх, эрүүл аюулгүй орчинд өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлд туслах зорилгоор байгуулагдсан “Залуус” төвийн хүүхдүүдийг албан бус боловсролын эчнээ сургалтанд хамруулснаас энэ хичээлийн жилд 4 хүүхэд бүрэн бус боловсролын гэрчилгээтэй болж, улмаар 3 хүүхдийг Шаамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцууллаа. Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн гэр бүлээр нь дамжуулан нийгмийн халамж үзүүлэх, гэр бүлийн гишүүдийг сургалтанд хамруулах, ажлын байранд зуучлах зэрэг ажлыг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран төсөл, хөтөлбөрт хамруулж, гэр бүлд нь хүрч ажиллалаа. Ерөнхий	70	30

			боловсролын сургуульд хамрагддаггүй, хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдийн чадавхи, авъяасыг нээн илрүүлэх цаашид хөгжих боломжтойг батлан харуулах, нийгэмшүүлэх зорилгоор Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг сумдын 150 хүүхдийг гэр бүлийнх нь хамтаар хамруулан зөвлөгөө, сургалт зохион байгуулах, сэтгэл санааны болон материаллаг дэмжлэг үзүүлэх, бүтээлч сэтгэхүй хөгжлийн дадлага ажил, сурталчилгаа, хамтын ажиллагааны хүрээг тэлэх, зөв хандлага төлөвшүүлэх зэрэг ажлуудыг хийлээ.		
31	1.5.9	Хүүхдийг дамлан худалдах, тэднээр аюултай нөхцөлд, албадан хөдөлмөр хийлгэх, тэднийг бэлгийн мөлжлөг болон бусад хууль бус үйл ажиллагаанд ашиглах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгана.	Хүүхдийн тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Өмгөөлөгчдийн баг, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын газар хамтран хяналт шалгалтыг хийж, Ерөө сумын “Болд төмөр-Ерөө гол” ХХК-д насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой 2 зөрчил илэрч, холбогдох арга хэмжээг авлаа. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг нэг цэгээс хүргэхийн тулд шүүх, цагдаа, прокурор, эмнэлэг, халамжийн байгууллагуудын хүүхдийн асуудал хариуцсан ажилтнуудтай хамтран ажиллаж, “Хүн худалдаалах ба хүүхэд эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөгөөс хамгаалах асуудал” сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд 70 нийгмийн ажилтан оролцож, сургагч багшаар бэлтгэгдлээ. Монголын Үндэсний их баяр, Ардын хувьсгалын 88 жилийн ой болон Атар газар эзэмшсэний 50 жилийн ойд зориулсан төвийн бүсийн хурдан морины уралдаанд оролцогч хүүхдүүдийг ослын даатгалд бүрэн хамруулах арга хэмжээг авч ажиллалаа. Аймгийн хэмжээнд нийт 316 хөдөлмөр эрхлэгч хүүхэд байгаагаас Хөдөө аж ахуйн салбарт 20, Хурдан морь унаач хүүхэд 281, бусад үйлчилгээний салбарт 10 уул уурхайн салбарт эцэг эхээ даган улирлын чанартай хөдөлмөр эрхлэгч 6 хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа тоон судалгаа гарсан бөгөөд эдгээр хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх талаар эрүүл мэндийн сургалтыг сум, өрхийн эмч нартай хамтран сургалт явуулж, хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.	100	30
<b>Хоёр.Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилт:</b>					
Эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшинг улам бататган, үйлдвэржилтийн бодлогыг тууштай дэмжиж, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, тээвэр, холбоо, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг сайжруулан, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгоно.					
<b>2.1.Макро эдийн засаг, санхүүгийн бодлого</b>					
32	2.1.7	Төсвийн зарлагыг зохистой түвшинд хязгаарлан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлж, төсвийг алдагдалгүй байлгах бодлого баримтална.	2009 онд орон нутгийн төсөвт 10781744.9 мянган төгрөгийн орлого оруулж, 6280869.9 мянган төгрөгний зарлага санхүүжилт хийж, 6240100.0 мянган төгрөг улсад төвлөрүүлэн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 102.8 хувьтай, сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 108.9 хувиар биелсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 981568.5 мянган төгрөгийн хөрөнгө	100	30

			оруулалт хийж, орон нутгийн зарлага санхүүжилтэнд 6328599.2 мянган төгрөг, улсын төсвөөс санхүүждэг төсвийн байгууллагуудад гэрээнд заасны дагуу санхүүжилтэнд 22932800.0 мянган төгрөг, нийт 29261399.2 мянган төгрөгийн зарлага санхүүжилт хийж, улсын төсөвт 6240100.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4260884.1 мянган төгрөг төвлөрүүлэн аймаг өөрийгөө бүрэн санхүүжүүлж, төсвийн алдалгүй ажиллалаа.		
33	2.1.20	Албан ёсны болон захиргааны, салбарын статистикийн тогтолцоо, арга зүйг боловсронгуй болгон хөгжүүлнэ.	Тус зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн албан ёсны статистик мэдээллийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, боловсронгуй болгох, хөгжүүлэх зорилго бүхий “Сэлэнгэ аймагт албан ёсны статистикийг хөгжүүлэх” хөтөлбөрийг боловсуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100	50
34	2.1.25	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид зөвлөгөө өгөх, дэмжиж туслах төв, инкубатор байгуулж, аж ахуй эрхлэхэд төрийн зүгээс учруулдаг дарамтыг арилгана.	Монгол Улсын Засгийн газраас олгож буй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн журмын дагуу аймагт төсөл сонгон шалгаруулах дэд комисс байгуулж, аймгийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-г байгуулан ажиллах журмыг батлуулж, Засгийн газрын болон аймгийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас нийт 92 иргэн, аж ахуйн нэгжид 2.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлөх нөцхөлтэйгээр олголоо. Нийт олгогдсон төслүүдээс үйлдвэрлэлээ өргөжүүлэх, шинээр үйлдвэрлэл эрхлэх, ажлын байр бий болгох чиглэлээр мал аж ахуй салбарт 20, газар тариалангийн салбарт 15, ахуйн үйлчилгээний салбарт 4, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт 6, хөнгөн үйлдвэрийн салбарт 14, хүнсний үйлдвэрийн салбарт 12, гахайн аж ахуйд 3, зөгийн аж ахуйд 2, үйлчилгээний салбарт 8 төсөл тус тус шалгарч үйл ажиллагаа эхлэх, тогтворжуулахад дэмжлэг үзүүлснээр нийт 188 ажлын байр шинээр бий болголоо.	100	30
<b>2.2.Үйлдвэржүүлэх бодлого</b>					
35	2.2.6	Дотоодын түүхий эдэд түшиглэн цемент, арматур төмөр хийц, шил зэрэг барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлнэ.	Шаамар суманд тоосгоны үйлдвэр байгуулахаар Сүхбаатар сумын “Халиун-Уул” ХХК-ий төслийг сонгон шалгаруулж хуучин ашиглагдаж байсан Буурлын овооны улаан тоосгоны үйлдвэрт тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”-аас 102.0 сая төгрөгийн зээл олголоо. Мөн дотоодын үйлдвэрлэлээр барилгын материалын блокны үйлдвэрийг барьж байгуулахаар иргэдийн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж 4 төсөлд 30.0 гаруй сая төгрөгийн зээлийг олгож, барилгын материалын үйлдвэрлэлт 0.8 хувиар нэмэгдсэн байна.	100	30
36	2.2.7	Аймгуудын онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг үйлдвэр, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулж, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор сумдаас 2009 онд байгуулах жижиг, дунд үйлдвэрийн судалгаа авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд саналаа хүргүүлсэн. Сум орон нутгийн онцлогийг харуулсан болон суманд байдаггүй	70	30

			жигжиг дунд үйлдвэрийг байгуулахаар орон нутгийн иргэн, аж ахуй нэгж, сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж байна.		
37	2.2.26	Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур зэрэг суурин газруудад эхэлсэн эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	"Алтанбулаг худалдааны чөлөөт бүс"-ийн Захирагчийн алба нь аймгийн төв Сүхбаатар суманд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна. 2009 онд 400кв-1ш, 630кв-1ш, 160кв-2ш мөн 3км-ийн урттай 6кв-ын агаарын дэд өртөөг байгуулан, улсын комисст хүлээлгэж өглөө. Мөн 630кв-ын 2 трансформатор, 6/0.4кв-ын хаалттай дэд өртөө 1, 800м3 багтаамжтай цэвэр усны сан байгуулж, цэвэр усны эх үүсвэрт шугам тавих ажлыг эхлүүлээд байна.	70	30
38	2.2.30.	"Чацаргана" төслийг хэрэгжүүлэх, энэ төслийн хүрээнд улсын хэмжээнд эхний ээлжинд 20 мянган гектар талбайд чацаргана тариалж, түүнийг боловсруулах үйлдвэр байгуулна.	"Жимс, жимсгэнэ" аймгийн хөтөлбөрийн хүрээнд орон нутгийнхаа онцлогт тохирсон байгаль цаг уурт дасан зохицох чадвартай тарьц суулгацаар хангах арга хэмжээ авч Мандал, Зүүнбүрэн, Сайхан, Орхонтуул, Шаамар, Хүдэр, Баянгол сумдад 80.4 га жимс, жимсгэнэ тариалсны дотор 72.0 га-д чацарганы 7 төрлийн сорт, 8.4 га-д үхрийн нүд тариаллаа. Сайхан, Сүхбаатар, Алтанбулаг суманд чацарганы аж ахуй байгуулахад 4 аж ахуйн нэгж, 2 иргэнд дэмжлэг үзүүлэн 103.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамруулснаар чацаргана тариалалт 30 га-гаар нэмэгдлээ.	100	30
<b>2.3. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого</b>					
39	2.3.1	Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээ авна.	Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилгоор "Монгол улсын хүнсний үнийн хөөрөгдөлд өртсөн бага орлоготой өрхийн аж ахуйнуудыг дэмжих төсөл" (ТСР/MON/3202)-д Сэлэнгэ аймгаас хамрагдах 1150 өрхийн судалгааг нэгтгэн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлснээр 86.3 тн төмсний, 202.5 кг хүнсний ногооны үр буцалтгүй тусламжаар олгууллаа. Мандал суманд шилмэл сортын төмсний үр үйлдвэрлэхэд 30 сая төгрөг, Сүхбаатар суманд төмс, хүнсний ногоо тариалахад 6.0 сая төгрөгийн зээлийг аймаг хөгжүүлэх сангаас олгоод байна.	100	50
40	2.3.5	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх "Атрын 3 дахь аян"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, усалгаатай тариалан эрхлэх, техникийн парк шинэчлэлтийн бодлогыг боловсруулж, техник, технологийн шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлж, хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлнэ. Шинэ төрлийн таримал тариалах, үр сортын шинэчлэл хийх, таримал ургамлыг хамгаалах тогтолцоо бүрдүүлнэ.	Тайлант онд нийт 140715 га талбайд үр тариа, 3323 га-д техникийн ургамал, 2834.5 га-д төмс, 1709.7 га-д хүнсний ногоо тариалж 211359 тн үр тариа, үүнээс 209669 тн буудай, 822 тн арвай, 206 тн овъёос, 39 тн гурвалжин будаа, 16 тн бог будаа, 412 тн тэжээлийн ургамал, 3062 тн техникийн ургамал, 441124.4 тн төмс, 29992.8 тн хүнсний ногоо тус тус хураан авч га бүрээс үр тариа 15.5 цн, төмс 155.6 цн, хүнсний ногоо 175.5 цн-ийг хураан авсан нь өнгөрсөн оныхоос үр тариа 0.6 цн-ээр илүү байна. 500-гаас дээш талбайтай 42 аж ахуйн нэгжид ХТ3-150-09 маркийн зүтгэх хүчний трактор 36, 300-500 га талбайтай аж ахуйн нэгж иргэдэд МТ3-1221 маркийн зүтгэх хүчний трактор болон хятад улсад үйлдвэрлэсэн трактор 30, төмс хүнсний ногооны зориулалттай 35 морины хүчтэй төмсний иж бүрдэл техник 8 ширхэгийг тус тус олголоо. Усалгаатай үр тариа 4176 га-д тариалж өмнөх оныхоос	100	50

			1269 га-гаар буюу 54.6 хувиар давуулан биелүүлсэн байна.		
41	2.3.7	Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг зааглан тогтоож, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, бүсийн хэмжээнд загвар фермерийн аж ахуй байгуулах бодлого барьж, энэ чиглэлээр нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран ажиллана.	2009 онд “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон эрхлэх бүс нутаг болгох боломж” зөвлөлгөөнийг малчид, тариаланчдын төлөөлөл, сумдын удирдлага, мэргэжилтэн нарыг оролцуулан зохион байгуулж, тэдний санал, хүсэлтийг үндэслэн аймгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэлийг тодорхойлсон. Мөн бусад аймгийн малчдад хандаж уриалга гаргаж хүргүүллээ. Зөвлөлгөөний шийдвэрийг баталгаажуулах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, “Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутаг тогтоох тухай” тогтоолыг гаргуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Цагааннуур, Орхон, Зүүнбүрэн, Хүдэр, Ерөө, Шаамар сумд малчид, тариаланчдын зөвлөлгөөн зохион байгуулж, бодлого, чиглэлээ тодорхойлсон байна.	100	50
42	2.3.12	Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг олон улсын жишгийн дагуу хийж, мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлэх, сумдын мал эмнэлэг, үржлийн нэгж болон Биокомбинатыг хөрөнгө оруулалтаар дэмжиж, дотоодын үйлдвэрийн малын эм, вакцины чанарыг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлнэ.	Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх талаар сумдын мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн захирал мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан бөгөөд үр дүнг жилийн эцэст тооцож ажиллалаа. Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн чадавхийг сайжруулах зорилгоор Европын холбооноос хэрэгжүүлж буй “Малын эрүүл мэнд, зах зээл” төсөлд хамруулж хөнгөлөлттэй нөхцөлөөр эм бэлдмэл, багаж тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг зохион байгуулсан.	100	30
43	2.3.13	Хөдөө аж ахуйн эдэлбэр газар ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, газрын нөөцийн болон төлөв байдлын мэдээллийн нэгдсэн сантай болох, бэлчээрийг хамгаалах, сайжруулах, усжуулах, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлнэ.	Аймгийн хэмжээнд тариалангийн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа 381 аж ахуйн нэгж байгууллагын 263230.46 га-г, 396 иргэний 33820.56 га-г үр тарианы зориулалтаар, 137 аж ахуйн нэгж байгууллагын 2664.44 га-г, 2809 иргэний 3186.68 га-г төмс хүнсний ногооны зориулалтаар сум, нэгж талбар тус бүрээр нь бүртгэж тоон хэлбэрт оруулж мэдээллийн санг үүсгээд байна. Аймгийн хэмжээний тариалангийн талбайн тооллогонд нийт 7633 нэгж талбарын 319453.12 га талбай хамрагдсанаас 4081 нэгж талбарын 309325.0 га-г үр тарианы зориулалтаар, 3502 нэгж талбарын 6944.49 га-г төмс, хүнсний ногооны зориулалтаар 50 нэгж талбарын 3144.38 га нь атаржсан газарт тоологдсон байна. Тооллогод хамрагдсан нийт талбайн 97.3 хувь буюу 310826.11 га нь кадастрын зурагт орж, 861 нэгж талбарын 8627.01 га газар кадастрын зурагт ороогүй байгаагаас гадна нилээд хэмжээний талбай хуваагдаж шинэ нэгж талбар үүсгэхээр тоологдлоо.	100	50
44	2.3.15	Услалтын систем засварлах, шинээр барихад улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	Услалтын систем барих сэргээн засварлах иргэд, аж ахуйн нэгжүүдийн тендерт оролцох хүсэлтийг дэмжиж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлан 6 аж ахуйн нэгж, сэргээн засварлахаар 1 аж ахуйн нэгж, иргэний өмчлөлөөр 3 сумын 3 иргэн	100	50



			тендерт шалгарч 4.8 тэрбум төгрөгнөөс улсын төсвөөс 1 тэрбум 124 сая төгрөг авч усалгаатай тариалангийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэх зорилтыг 54.6 хувиар давуулан биелүүлээд байна.		
45	2.3.17	Хөрсний эвдрэлтэй тэмцэх шинэ технологи ашиглан атаршсан талбайг тариалангийн зориулалтаар сэргээн ашиглах ажлыг эрчимжүүлнэ.	Хөрсний элэгдэл эвдрэлтэй тэмцэх талаар шинэ технологи боловсруулах ажлыг Эрдэм шинжилгээний байгуулагад захиалга өгөх арга хэмжээг авч ажиллаж байна. Нэг явалтаар олон үйдэл хийдэг техникийг сонгох, хөрсийг бордох, сайн сортыг сонгох зэрэг судалгааны ажлыг хийж байна.	30	10
46	2.3.18	Малын угаалга, туулгалт, вакцинжуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс хариуцан санхүүжүүлнэ.	Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний эм бэлдмэлийн үнийг улсын төвлөрсөн төсвөөс, халдварт өвчний үйлчилгээний зардлыг орон нутгийн төсвөөс 161.0 сая төгрөгийн санхүүжилт олгосноор аймгийн хэмжээнд 32 мал эмнэлгийн үржлийн нэгж үйлчилгээ үзүүлж, 8214 өрхийн 1432.0 мянган малд мал эмнэлгийн үйлчилгээг үзүүллээ.	100	50
47	2.3.19	Хүлэмжийн ногоо болон жимс, жимсгэний аж ахуйг дэмжинэ.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зарласан жимсний аж ахуйн тендерт Жавхлант, Алтанбулаг, Зүүнбүрэн, Мандал, Ерөө, Сүхбаатар, Шаамар, Түшиг сумын нийт 12 иргэн, аж ахуйн нэгжийн төслийг дэмжсэнээр Түшиг сумын “Чацаргана” төсөл шалгарч, Сүхбаатар сумын 2 иргэнд өвлийн хүлэмж авахад зориулан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”-гаас 26.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоход дэмжлэг үзүүлсэн. Сүхбаатар суманд хүлэмжийн аж ахуй эрхлэхэд 10.0 сая төгрөгийн зээлийг аймаг хөгжүүлэх сангаас олгоод байна. Сайхан, Сүхбаатар, Алтанбулаг сумын 4 аж ахуйн нэгж, 6 иргэнд чацарганы аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэн 101.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамруулснаар жимс, жимсгэний тариалалт 40 га-гаар нэмэгдлээ. Мөн Улаанбатар хотын “Нийслэл хүнс трейд” ХХК Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар сумын иргэдэд 10 хүлэмжийг олгож, Вьетнам сортын өргөст хэмх тариалуулах ажлыг зохион байгуулснаар тариалах ургамлын төрлийг олшруулж, хангамжийг нэмэгдүүлээд байна.	100	50
<b>2.4. Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого</b>					
48	2.4.25	Мэдээлэл холбооны дэд бүтцийг өргөтгөн шинэчилж, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг өргөжүүлж, өрх бүрт хүртээмжтэй болгоно.	Сумдыг холбооны тоон технологид шилжүүлэх арга хэмжээг авч 2009 оны жилийн эцсийн байдлаар нийт сум, тосгодыг шилжүүллээ. Мобиком, Скайтель, Юнител, Жи-мобайл зэрэг бүх үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрч, урьд оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгч 9.3 хувиар, мобикомын хэрэглэгч 12.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.	90	50
49	2.4.30.	Шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөн шинэчилж, мэдээллийн технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлнэ.	“Монгол шуудан” ХХК нь 2008 оноос эхлэн гадаадын хэвлэлийг Алтанбулаг-Хиагт боомтоор дамжуулан хүлээн авч, ялган Улаанбаатар, Орхон, Дархан-Уул аймаг руу хүргүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд зарим сумдад шуудан хүргэх давтамжийг 2-3 удаа болгон үйл ажиллагааг өргөжүүллээ.	90	30

50	2.4.36.	Ховд, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Замын-Үүд, Сүхбаатар хотуудыг улсын зэрэглэлтэй хотын статустай болгож, хотын хөгжлийн цогц арга хэмжээ авна.	Аймгийн төв Сүхбаатар хотыг улсын зэрэглэлтэй хотын статустай болгох зорилгоор нарийвчилсан судалгааг хийх тусгайлсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж, судалгааны үр дүнг үндэслэн санал боловсруулж Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт хүргүүлээд байна.	70	30
<b>2.5. Орон нутгийн хөгжлийн бодлого</b>					
51	2.5.2.	Сумдад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор 50.0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй “Үйлдвэрлэл хөгжүүлэх сан” байгуулж ажиллуулна.	Монгол Улсын Засгийн газраас олгож буй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн журмын дагуу аймагт төсөл сонгон шалгаруулах дэд комисс байгуулж, аймгийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-г байгуулан ажиллах журмыг батлуулж, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн төслийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шалгаруулж, 2009 онд нийт 92 аж ахуйн нэгж, иргэдэд 2.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна. Мандал, Баянгол сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Бороо гоулд” ХХК-ий хөрөнгө оруулалтаар сумын “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх” сан байгуулан орон нутгийн иргэдэд үйлдвэрлэл эрхлэхэд хөнгөлөлттэй зээл олгож, үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна.	100	50
52	2.5.5.	Аймаг хоорондын болон тээвэрлэлт, аялал жуулчлалын гол чиглэлийн авто замыг сайжруулж, тодорхой хэсгийг хатуу хучилттай болгоно.	Сүхбаатар сумын доторх 3.6 км шороон замыг хайрган хучилттай болгож, хатуу хучилттай замыг сэргээн засварлаж, аймгийн ургац хураалтын цагаар Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур чиглэлийн 70 км замд урсгал засварыг хийлээ.	70	30
53	2.5.10.	Атрын 3 дахь аяны хүрээнд тухайн аймгийн нутагт бүрэн ашиглагдаагүй байгаа тариалангийн талбайг ашиглан тариалан эрхэлж, газар тариалангийн техникийн паркийг шинэчилнэ.	Техник шинэчлэлийн хүрээнд газар тариалангийн аж ахуй нэгжүүдэд хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр ХТЗ-150-09, МТЗ-1221, “Жон деер” маркийн техник тоног төхөөрөмжүүдийг олгосноор 136.8 мянган га-д тариалалт хийж, 137.5 мянган га талбайд уринш бэлтгэн нийт эргэлтийн талбайн 96.5 хувийг ашиглах нөхцөлийг бүрдүүллээ. Мөн төмс, хүнсний ногооны зориулалттай 35 морины хүчтэй төмсний иж бүрдэл техник 8 ширхэгийг олголоо. Аймгийн хэмжээний тариалангийн талбайн тооллогонд нийт 7633 нэгж талбарын 319453.12 га талбай хамрагдсанаас 4081 нэгж талбарын 309325.0 га-г үр тарианы зориулалтаар, 3502 нэгж талбарын 6944.49 га-г төмс, хүнсний ногооны зориулалтаар 50 нэгж талбарын 3144.38 га нь атаржсан газарт тоологдсон байна. Тооллогод хамрагдсан нийт талбайн 97.3 хувь буюу 310826.11 га нь кадастрын зурагт орж 861 нэгж талбарын 8627.01 га газар ороогүй байгаагаас гадна нилээд хэмжээний талбай хуваагдаж шинэ нэгж талбар үүсгэхээр тоологдлоо. Тайлант онд 190 нэгж талбарын 2139 га үр тарианы талбай, 39 нэгж талбарын 70.5 га төмс, хүнсний ногооны талбайд хэмжилт хийж нэгдсэн зураглалд оруулаад байна.	100	30
<b>Гурав. Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилт:</b>					
Экосистемийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлэн					

хөгжлийн тогтвортой орчныг бий болгох, түүнд түшиглэсэн аялал жуулчлалын цогц бодлого хэрэгжүүлнэ.					
54	3.3	Хот, суурин газруудад хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж, хог боловсруулах үйлдвэр байгуулна.	Хог хаягдлыг бууруулах “Сэлэнгэ цэвэр орчин” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд “Хоггүй сум-Цэвэр орчин” сэдэвт 1 сарын аяныг зохион байгуулан ажилласнаар аймгийн хэмжээний хог хаягдлыг 40 хувиар буурууллаа. Мөн Сүхбаатар сумын 5-р багт хаягдал гялгар уут, хуванцар хог хаягдлыг боловсруулах, ясны гурилаар тэжээл үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг “Тогтвортой амьжиргаа” төслийн санхүүжилтээр суурилуулаад байна. Мөн Сүхбаатар суманд хог хаягдлын шинэ технологи нэвтрүүлж, ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрийг ашиглалтанд оруулах бэлтгэл ажлыг хангаад байна.	100	50
55	3.6	Говь, хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд унаган ургамлыг тарималжуулах, хур тунадас нэмэгдүүлэх, ус хуримтлуулах, хиймэл нуур, цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээ авч, “Ус” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Засгийн газрын “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, усны талаар төрөөс баримтлах бодлогыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор аймгийн “Ус” хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын удирдамжаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий Газар хамтран Баянгол, Мандал, Ерөө, Хүдэр сум, Бугант тосгонд үйл ажиллагаа явуулж буй алтны уурхайнуудад Усны тухай, Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтэнд технологийн хяналт тавин мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран байнгын хяналт тавьж Хятад улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд мөнгөн ус хэрэглэж алт олборлодог тээрэм, хаягдал ихтэй минидраг ашиглаж байсныг таслан зогсоосноор үйлдвэрлэлд хэрэглэдэг усныхаа 70 хувийг эргэлтээр дахин ашигладаг боллоо. Усны шинэчилсэн хуулийг удирдлага болгон, гадаргын усны эх булагийн нөөцийг сайжруулах зорилгоор манай аймгийг дамжин урсдаг Сэлэнгэ, Орхон, Ерөө, Хараа, Туул голын сав газрын зөвлөл, зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгууллаа.	100	70
56	3.8	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх гадаад, дотоод санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	“Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн хөтөлбөрийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 19-р тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хөтөлбөрийг сурталчлах зорилгоор “Цөлжилтийн эсрэг хамтдаа” сэдвээр малчид, тариаланчидтай ярилцлага зохион байгуулж, санал бодол солилцож цаашид газар тариалангийн талбайг хамгаалах зурвас байгуулах талаар зөвлөмж гарын авлага бэлтгэн сумдад хүргүүлээ. Мөн Нэгдсэн үндэсний байгууллагын төсөл, хөтөлбөрийн газрын санхүүжилтээр бэлчээрийг хамгаалах, энгийн аргаар нөхөн сэргээх зорилгоор “Бэлчээрийн менежмент”	100	70

			төслийг Баянгол суманд хэрэгжүүлж байна. Орхонтуул суманд голын ай савд ургаж байгаа бургасан шугуйг хамгаалах нөхөн, сэргээх төслийг хэрэгжүүлж байна.		
57	3.14.	Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.	Тусгай хамгаалалттай газрын сүлжээг сайжруулах зорилгоор Геомэдээллийн үндэсний төвийн төсөлтэй хамтран тусгай хамгаалалттай газрын мэдээллийн сантай боллоо. Энэхүү мэдээллийн санд орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын мэдээллийг нэгтгэн улмаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий Хонин нуга, Хүдэр сумын Уялга зэрэг газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авлаа.	100	30
58	3.15.	Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх тогтвортой менежментийг бий болгож, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, модны хэрэглээг импортоор хангах санаачилгыг дэмжинэ.	2009 онд улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар Алтанбулаг сумын Дүгэрээ, Их Бага цоорхой, Цагааннуур сумын Оргих, Зүүнбүрэн сумын Цармын эрээн, Тужийн нарс зэрэг тусгай хамгаалалттай газруудад 1365 га ойжуулалт хийсэн ба амьдралт нь 75 хувьтай байна. Сүүлийн жилүүдийн байгаль цаг уурын өөрчлөлтийн улмаас шилмүүст модны үр боргоцой ургахгүй байгаад дүгнэлт хийн байнгын талбайтай болох зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр 295 га талбайг тусгаарлах ажлыг Алтанбулаг, Шаамар зэрэг сумдад ойн эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажиллалаа. Мөн мод бэлтгэх эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр 1066 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Аймгийн хэмжээнд Ойн санг нутгийн иргэдэд гэрээгээр эзэмшүүлэх, хамгаалуулах бодлогыг хэрэгжүүлж Мандал, Шаамар, Хүдэр, Хушаат, Баруунбүрэн, Ерөө, Түшиг, Цагааннуур, Алтанбулаг, Сант зэрэг 12 суманд 67 нөхөрлөл 1430 гишүүнтэй 285949 га талбайг эзэмшиж байна. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн ойн менежментийн төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлийн хяналт тавин ажиллалаа.	100	30
59	2.3.4.	Орчин үеийн техник, технологи нэвтрүүлж хүн амын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны цэвэр усны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, усны хатуулаг, эрдэсжилт ихтэй сум, суурин газруудад ус зөөлрүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийг мөрдүүлэн ажиллаж байна. Мандал, Сүхбаатар, Сайхан сум, Бугант тосгон, Мандал сумын Тарнийн амралт, Баянгол сумын төвийн бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн технологи ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дэргэдэх гидрохимийн лабораторийн шинжилгээний дүнгээр Мандал сумын “Цант-Орхон” ХХК ус цэвэрлэх байгууламжийн бохир ус цэвэрлэгээний түвшин 54.6 хувь, Сайхан сумын “Гавшгай-Ус” ХХК ус цэвэрлэх байгууламжийн бохир ус цэвэрлэгээний түвшин 68.2 хувьтай байсныг цэвэрлэж шүүрүүлэх талбайд оруулж бохир усыг ариутгалаа.	100	30

			Сүхбаатар сумын “Урсгал ус” ХХК 3.0 сая төгрөгөөр бактериологи шинжилгээний лаборатори байгуулж, Сайхан сумын “Хөтөл” ХХК 100,0 гаруй мянган төгрөгийн урвалж бодис шил сав шинээр авч, Мандал сумын “Цант-Орхон” ХХК цэвэрлэх байгууламждаа 5,2 сая төгрөгийн, Зүүнхараагийн Спиртийн үйлдвэр 40,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж тус тус авч усны лабораторийн материаллаг баазыг бэхжүүлээ.		
<b>Дөрөв. Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилт</b>					
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэхийн хамт иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, тогтвортой үйл ажиллагаа, ил тод байдал, төрийн албаны ур чадвар, хариуцлагын тогтолцоог өндөржүүлж, эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.					
<b>4.1. Эрх зүйн бодлого</b>					
<b>60</b>	4.1.3	Батлагдсан хууль тогтоомжийг төв, орон нутагт цаг алдалгүй хүргэх, эрх зүйн албан бус сургалтыг мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах ажлын цар хүрээ, хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.	Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг Жавхлант, Хушаат сумдад, Нээлттэй хаалганы өдрийг Цагааннуур, Жавхлант, Хушаат, Хүдэр, Ерөө, Зүүнбүрэн сум, Бугант, Дулаанхаан тосгонд зохион байгуулж, энэ ажил, арга хэмжээний хүрээнд хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа мэдээлэл, лавлагаа, зөвлөгөө, туслалцааны ажил үйлчилгээг үзүүлэлтээр шалгаж, арга зүйн заавар, зөвлөмж өгч ажилласан. Сумдын Засаг даргын Тамгын газарт Хууль эрх зүйн асуудад хариуцсан ажлын байр бий болгож, шинээр томилогдсон ажилтнуудад Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажил үйлчилгээг орон нутагт хэрхэн зохион байгуулах талаар зөвлөмж боловсруулан хүргүүлэх, ажлын байран дээр нь арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хийлээ. Эрх зүйн сургалт, мэдээлэл сурталчилгааны холбогдолтой заавар, зөвлөмжийн 20 гаруй төрлийн номоор хангалт хийж, Хууль зүй дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хууль тогтоомжийн цахим сангийн баяжилтыг тогтмол авч орон нутгийн иргэдэд үйлчилж байна. Хууль тогтоомжийг сум орон нутагт шуурхай хүргэх үүднээс сум, байгууллагад Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ “Legalinfo”-г ашиглуулах хууль, тогтоомжийн цахим сангийн баяжилтыг хагас жил тутам хийж, сумдын Засаг даргын Тамгын газар, агентлагуудад Төрийн мэдээлэл, Хууль зүйн мэдээлэл сэтгүүлийг албан хэрэгцээний зориулалтаар захиалуулан ашиглуулах зэрэг нэгдсэн бодлого зохицуулалтын арга хэмжээ авсан. Аймгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд хуулийн булан, хуулийн цаг хэлбэрээр хууль эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна. Эрх зүйн албан бус сургалтын үр нөлөөг дээшлүүлэх, иргэдийн “Эрх зүйн хөтөч” номын ашиглалтыг сайжруулах үүднээс “Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 30 тоот захирамж гаргаж сургалтыг багууд дээр сар тутам зохион байгуулан хэвшиж, 49 баг тус бүрт 8-12 удаагийн сургалт зохион	100	50

			байгуулж 18.000 гаруй иргэнийг хамруулсан үр дүнд хүрсэн.		
<b>4.2.Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого</b>					
61	4.2.3	Цагдаа, дотоодын цэргийг нийгмийн хэв журмыг хамгаалахад шаардагдах зориулалтын техник хэрэгслээр үе шаттайгаар хангана.	Аймгийн цагдаагийн байгууллагад нийгмийн хэв журмыг сахин хамгаалахад шаардлагатай техник хэрэгслийн судалгааг авч нэгтгэн авах арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөж ажиллалаа. Цагдаагийн ажил үйлчилгээний зориулалтаар Мандал, Хүдэр, Баянгол сум, Дулаанхан тосгонд автомашин, тусгай хэрэгсэл, компьютер, хурд хэмжигч зэрэг хангалт хийлгэж нийт 8.0 сая төгрөгийг зарцууллаа.	90	30
62	4.2.5	Цагдаагийн ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор цагдаагийн бүх хэсэг, тасагт байнгын пост /кабон систем/ барьж байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж дуусгана.	Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Цагдаагийн кабон систем нэвтрээгүй Сант, Орхон, Орхонтуул, Сайхан, Хушаат, Шаамар, Түшиг, Баруунбүрэн сумдад нэвтрүүлж цагдаагийн үйлчилгээг ойртуулахаар тусгаж 2009 онд Шаамар, Сүхбаатар сумын 5 дугаар багт Цагдаагийн кабоны барилгыг ашиглалтад орууллаа.	100	30
63	4.2.6	Гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийхэд дэвшилтэт технологи бүхий лабораторийн техник, арга, хэрэгслийг ашиглан хараат бус, шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв дүгнэлт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.	Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 67 тоот тогтоолоор аймагт Шүүхийн шинжилгээний албыг шинээр байгуулсан. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Беларусь Улсын Шүүх эмнэлгийн албанаас хамтын ажиллагааны гэрээний дагуу тус улсын Шүүх эмнэлгийн албанаас гистологи ба биологийн лабораторийн чиглэлээр мэргэжилтнүүд урьж сургалт зохион байгууллаа. Дээрх сургалтанд аймгийн Шүүхийн шинжилгээний албаны шинжээч нарыг 14 хоногийн хугацаатай хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Аймгийн Шүүхийн шинжилгээний албыг шаардлагатай мэргэжилтэн албан хаагчдаар бүрэн хангах арга хэмжээг авч ажиллалаа.	100	50
64	4.2.9	Мал хулгайлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх улс, аймаг, сумын санд төрөөс жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлж, мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.	Мал хамгаалах байгууллага, иргэдийн санал, санаачилгыг дэмжин ажиллаж байна. Цагааннуур, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Баянгол, Хүдэр, Шаамар зэрэг сумдад малчдын зөвлөгөөн зохион байгуулагдаж мал хамгаалах сайн дурын хамтын нөхөрлөл, холбоо болон Төрийн бус байгууллага байгуулж, Цагааннуур, Баруунбүрэн, Баянгол, Хүдэр сумдад мал хамгаалах нөхөрлөл, Зүүнбүрэн суманд малчдын эрх ашиг хамгаалах Төрийн бус байгууллага байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлээ. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал оруулж “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 86 дугаар тогтоол гаргуулан хэрэгжүүлж ажилласан. Аймгийн Засаг даргаас малын хулгайтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд тайлант онд нийт 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Малын хулгай болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд зориулж сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдэд тус бүрт 1.5 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаас сум бүрт хоёроос доошгүй	100	50

			<p>мал хамгаалах нөхөрлөл, холбоо байх чиглэл өгсний дагуу Сүхбаатар, Мандал, Баянгол, Хушаат, Түшиг, Хүдэр, Алтанбулаг зэрэг 12 суманд малын хулгайтай тэмцэх, хамгаалах сайн дурын малчид иргэдийн нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгж, байгууллагын 24 нэгж бий болгон ажиллуулж байна. Хөрш зэргэлдээ аймаг, орон нутгийн хууль хяналтын байгууллагуудын удирдах ажилтнуудын малын хулгайтай тэмцэх асуудлаар хамтарсан зөвлөлгөөн хийх саналыг Дархан-Уул, Орхон аймгийн Засаг дарга нар т хүргүүлж санал солилцсоны дагуу Орхон аймагт ажил хэргийн уулзалт зохион байгуулж, хамтран хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тохиролцлоо. ОХУ-ын Хиагтын районы хил хамгаалахад туслах зөвлөлтэй хамтарсан уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, Малыг хил дамнуулан хулгайлах болон алдуул хариулгагүй мал, хилийн бүсэд нэвтрэн хил дамнах асуудлаар санал солилцож гэрээ байгуулсан.</p>		
65	4.2.10	<p>Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, архидалт, согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхжүүлэн, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэхэд тавих хяналтыг чангатгаж, архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.</p>	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудын нөхцөл байдал, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, олгох зөвшөөрлийн журмын төслийг хэлэлцүүлэн 89 тоот тоогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, түүгээр үйлчилдэг, худалддаг аж ахуйн нэгжүүдийг аттестатчилж, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.</p> <p>Архины хор уршиг хөнөөлийг иргэдэд сурталчлах зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Архидалт мансуурлын эсрэг үндэсний төв, Дэлхийн зөн Олон улсын байгууллага, аймгийн Хүүхдийн төлөө хэлтэс, Өмгөөлөгчдийн холбоо хамтран ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд “Архидалт мансуурлын эсрэг хамтдаа” сэдэвт дэвжээ тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж хүүхэд залууст зохих сурталчилгаа мэдээллийг өглөө. Архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй өдөртэй болох хөдөлгөөн өрнүүлж 2009 онд 12 сум орон нутгийн онцлог иргэдийн амьдралын хэв шинжтэй уялдуулан архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй тусгай өдөртэй болох ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.</p>	100	30
<b>4.3.Хил хамгаалах бодлого</b>					
66	4.3.3	<p>Улсын хилийг “хугацаат цэргийн алба хаагч”-аар хамгаалуулдаг тогтолцоог өөрчилж, хил хамгаалах албыг удирдан зохион байгуулах үүргийг мэргэжлийн</p>	<p>Монгол Улсын хил хамгаалах талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсанаар мэргэжлийн чиг хандлагатай болгох, мэргэшсэн хилчдээр Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах шаардлагын үүднээс 2007 оноос</p>	90	30

		байгууллагаар, улсын хилийг хамгаалах үүргийг “мэргэшсэн гэрээт хилчин”-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.	хилийн цэргийн хэмжээнд 2 отрядын “Хутаг өндөр”, “Үзүүр ус” заставуудыг анхны гэрээт хилчдээр хангах туршилт явуулсан нь амжилттай хэрэгжсэн. 2008, 2009 онуудад хилийн 2, 7 дугаар /Түшиг, Хүдэр/ заставуудад гэрээт хилчний алба зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хийж, гэрээт хилчний албанд шилжүүлэн Улсын Хил хамгаалалтыг зохион байгуулан явуулж байна. Одоогоор гэрээт холбоочин зэрэг албан тушаалыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж байна.		
67	4.3.8	Хилийн боомтод ажиллаж байгаа цагдаа, хил, гааль, гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагын алба хаагчдын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	Хилийн Сүхбаатар, Алтанбулаг боомт дахь Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх албаны албан өрөө тасалгааны урсгал засвар, тохижилтонд зориулж аймгийн төсвөөс 500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллах орчинг сайжруулах арга хэмжээг авсан. Дээрх боомтуудад ажиллаж байгаа Цагдаа, Хил, Гааль, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх болон Хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаагаа явуулж байгаа нөхцөл байдлыг мэргэжлийн байгууллагаар судлуулах, иргэд үйлчилгээ хүртэгчдийн санал хүсэлтийг авах замаар судлан тогтоосон. Судалгааны дүгнэлтээр үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн байна гэсэн дүгнэлт гарсан.	100	50
<b>14.5. Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого</b>					
68	4.5.5	Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, хууль дээдлэх, авлигыг үл тэвчих ухамсар, соёлыг хэвшүүлж, ажиллах нөхцөл, баталгааг бүх талаар хангах замаар төрийн албыг чадавхижуулна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний холбогдох заалтад төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143-р тогтоол, 2009 оны 03-р албан даалгавар, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм”, Дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох тухай тусгайлан оруулж өгсөн. Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Төрийн албан хаагчийн мэдлэг, чадвар” аймгийн хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны өнөөгийн байдлын талаархи судалгаа, дүгнэлтийг үндэслэн Төрийн албан хаагчдын “Нийгмийн баталгаа хөтөлбөр”-ийг аймгийн Засаг даргын захирамжаар баталж төрийн албаны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэх зорилгоор нийт 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг тусгасан. Хөтөлбөрийг аймаг, сумдын нийт төр, төсвийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	50



69	4.5.10	Төрийн байгууллагын бүтцийг боловсронгуй болгон цомхотгож, төрийн албан хаагчдын давхардсан, сул орон тоог цөөлөх, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгон төсвийн 70 зарлагын хэмжээг эрс багасгана.	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 13 тоот тогтоолын дагуу төрийн байгууллагуудын бүтцийг боловсронгуй болгон цомхотгох ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2009 оны 8 дугаар захирамжийг батлан гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, албадын бүтцийг өөрчлөн шинэчиллээ. Мөн нутгийн захиргааны байгууллага болох сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц зохион байгуулалтыг тухайн сумын онцлог, хүн амын нягтшил, эдийн засгийн чадавхийг харгалзан аймгийн Засаг даргын 2009 оны 52-р захирамжаар шинэчлэн тогтоож мөрдөн ажиллаж байна. Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын санаачилгаар аймгийн Ажил олгогч эздийн холбоотой хамтран сүлжээ байгуулан авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн бодлого чиг үүрэг, үйл ажиллагааны талаар орон нутагт сурталчлан таниулах, иргэдэд шаардалгатай мэдээ, мэдээллийг хүргэх үүднээс аймгийн “Миний Монгол” ТВ, “Шинэ Гэгээ”, “Сэлэнгийн мэдээ” сонины газрууд, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, хамтран ажиллах зорилгоор аймгийн Улаан загалмай, Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан нийт 16.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	100	30
70	4.5.11	Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн албан хаагчтай хариуцлага тооцох, ил тод, шуурхай механизм бий болгож хэрэгжүүлнэ.	2009 онд зохион байгуулсан нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтны зөвлөлгөөний үеэр аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх, санхүүжилт авах тухай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, мөн энэхүү арга хэмжээний үеэр аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай 10 зүйл бүхий батламжийг байгууллаа. Тус батламжаар төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцохоор заасан нь төрийн албан хаагчтай хариуцлага тооцох, ил тод, шуурхай механизмыг бий болгосон төдийгүй тухайн жилийн ажлын үр дүнг тооцох гол шалгуур үзүүлэлтүүдийн нэг болгон ажиллаж байна.	100	50
<b>5.2. Батлан хамгаалах бодлого</b>					
71	5.2.7	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт бэлтгэх тогтолцоог төгөлдөршүүлж, бүсийн төвүүдэд байршилтай зэвсэгт хүчний анги, салбарыг түшиглэн бүсийн сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	Зэвсэгт хүчний Жанжин штабаас захиалсан цэргийн мэргэжлийн дагуу 60 цэргийн бэлтгэл үүрэгтэнг Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн сургалтын төвийг түшиглэн 14 хоногийн давтан сургалтанд хамруулснаар дайчилгааны бэлтгэл нөөц 60 хувьд хүрэн байна. Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн Номгон тосгон дахь сургалтын төвийн газрын зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад хандсан нь шийдвэрлэгдэх шатандаа байна.	100	50

<b>5.3. Гамшгаас сэргийлэх, хор нөлөөг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого</b>					
<b>72</b>	5.3.4	Мэргэжлийн хяналтын байгууллагыг орчин үеийн техник, технологи бүхий нэгдсэн лабораторитой болгож, материаллаг баазыг нь бэхжүүлэн, боловсон хүчний чадавхийг сайжруулна.	Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, хөнгөвчлөх, материаллаг бааз суурийг бэхжүүлэх зорилгоор 27.0 сая төгрөгийн үнэ бүхий багаж төхөөрөмжөөр хангах арга хэмжээг авч, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу болон орон нутагт зохион байгуулагдсан 15 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 21 улсын байцаагчийг хамрууллаа. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар Мэргэжлийн хяналтын Ерөнхий газартай хамтран “Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж нийт 73 улсын байцаагч хамрагдан зөвлөгөөнөөс 4 зүйл, 8 заалт бүхий зөвлөмжийг гарган нийт сумын Засаг дарга, улсын байцаагчдад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90	30
<b>73</b>	5.3.5	Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхэлж байгаа бүхий л үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлнэ.	Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас төлөвлөгөөт хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж давхардсан тоогоор 2286 байгууллага, аж ахуй нэгж, 794 салбар нэгж, 1670 цэг байгууламж, 5713 иргэнийг хяналт шалгалтанд хамруулан 3215 зөрчил илрүүлэн 79.1 хувийг арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа. Аймгийн Стандартчилал хэмжилзүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан үзлэг, шалгалтыг зохион байгуулж аймгийн хэмжээний 425 аж ахуй нэгжийн иргэдийн үйлдвэрлэж, борлуулж буй хүнсний бүтээгдэхүүн, үр тариа, хүнсний ногооны 1029 дээжинд 6781 үзүүлэлтээр химийн шинжилгээ, үйлдвэр үйлчилгээний орчны эрүүл ахуйн шинжилгээг 1111 сорьцонд хийснээс 617 дээж, 777 үзүүлэлтээр эрүүл ахуй, чанарын шаардлага хангахгүй гарсныг холбогдох арга хэмжээг авч зөрчлийг арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөмж хүргүүллээ.	90	50

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
СЭЛЭНГЭ АЙМАГТ ХАМААРАЛТАЙ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮНГИЙН НЭГТГЭЛ  
/2009 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2010.03.11

№	□□□□□□□□	Нийт зорилтын тоо	Биелсэн	Хэрэгжих шатандаа	Үүнээс							Нийт хувь	
					100%	90%	70%	50%	30%	10%	0	2009	2008-2012
<b>Нэг</b>	<b>Хүн ам, нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах</b>												
1	Эрүүл мэндийн бодлого	8	6	2	6	2	-	-	-	-	-	97.5	45
2	Боловсрол, соёл, шинжлэх ухаан	12	11	1	11	-	-	1	-	-	-	95.8	45
3	Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого	4	4	-	4	-	-	-	-	-	-	100	35
4	Нийгмийн хамгааллын бодлого	2	2	-	2	-	-	-	-	-	-	100	50
5	Хүн амын бодлого	5	3	2	3	-	2	-	-	-	-	88	38
<b>Хоёр</b>	<b>Үйлдвэржүүлэлтийн бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах</b>												
1	Макро эдийн засаг, санхүүгийн бодлого	3	3	-	3	-	-	-	-	-	-	100	36.6
2	Үйлдвэржүүлэх бодлого	4	2	2	2	-	2	-	-	-	-	85	30

3	Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого	9	8	1	8	-	-	-	1	-	-	92.2	43.3
4	Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого	3	-	3	-	2	1	-	-	-	-	83.3	36.6
5	Орон нутгийн хөгжил	3	2	1	2	-	1	-	-	-	-	90	36.6
<b>Гурав</b>	<b>Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах</b>	6	6	-	6	-	-	-	-	-	-	100	46.6
<b>Дөрөв</b>	<b>Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох</b>												
1	Эрх зүйн бодлого	1	1	-	1	-	-	-	-	-	-	100	50
2	Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого	5	4	1	4	1	-	-	-	-	-	98	38
3	Хил хамгаалах бодлого	2	1	1	1	1	-	-	-	-	-	95	40
4	Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого	3	3	-	3	-	-	-	-	-	-	100	43.3
5	Батлан хамгаалах бодлого	1	1	-	1	-	-	-	-	-	-	100	50
6	Гамшгаас сэргийлэх, хор нөлөөг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого	2	-	2	-	2	-	-	-	-	-	90	40
	<b>Бүгд</b>	<b>73</b>	<b>57</b>	<b>16</b>	<b>57</b>	<b>8</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>94.9</b>	<b>41.4</b>

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР